

“ХИШИГ-УУЛ” ХХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

2021 оны 04 сарын 28 ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*“Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг хойшлуулах тухай”*

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн Дугаар 104 “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” тогтоол, Компанийн тухай Хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 69.3, 69.6, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”, “Хишиг-Уул” ХК (“Компани” гэх)-ийн дүрмийн 7 дүгээр зүйлийн 7.32.3, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын тогтоолын тус тус үндэслэл болгон **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“ХЭЭХ”)-ыг 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр товлосон боловч бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор хурлын ирц бүрдээгүй тул ХЭЭХ-ыг 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 15 цагт 00 минутад Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 3-р хороонд байрлах “Peace tower”-ын 9 давхар 905 тоотбайранд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсүгэй. Үүнд:
 - Нэг.** Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
 - Хоёр.** Компанийн 2020 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
 - Гурав.** Компанийн 2021 оны Бизнес, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
 - Дөрөв.** Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хойшлуулах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор зохих баримт бичгийн хамт хүргүүлсүгэй.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр байхаар тогтоосугай.
5. Хурал зохион байгуулах комисст дараах нэр бүхий хүмүүсийг томилсугай:
 - I. Гүйцэтгэх захирал Я.Нэргүй.
 - II. Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН-н хуульч Т.Оюун-Эрдэнэ
 - III. Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН-н хуульчийн туслах Ш.Цэрэндолгор
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор өдөр тутмын 2-оос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, бүртгэл, хаяг нь тодорхой хувьцаа эзэмшигч нарт бичгээр мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Я.Нэргүй, тооллогын комиссын даргаар Нийслэлийн өмчийн газрын томилогдсон төлөөлөгч, гишүүнээр Т.Оюун-Эрдэнийг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГОНГОР